



**HAL**  
open science

Ya. Tserendagva, Jamiyan-Ombo Gantulga, Jérôme Magail

► **To cite this version:**

Ya. Tserendagva, Jamiyan-Ombo Gantulga, Jérôme Magail. . STUDIA  
ARCHAEOLOGICA, XXX (1-14), pp.5-20, 2011, 978 - 99962 - 1 - 229 - 1. hal-02498141

**HAL Id: hal-02498141**

**<https://hal.science/hal-02498141>**

Submitted on 6 Mar 2020

**HAL** is a multi-disciplinary open access archive for the deposit and dissemination of scientific research documents, whether they are published or not. The documents may come from teaching and research institutions in France or abroad, or from public or private research centers.

L'archive ouverte pluridisciplinaire **HAL**, est destinée au dépôt et à la diffusion de documents scientifiques de niveau recherche, publiés ou non, émanant des établissements d'enseignement et de recherche français ou étrangers, des laboratoires publics ou privés.



Tomus XXX

Fasciculus 1-14

МОНГОЛЫН  
АМЬСГАЛ  
ЭРЭГ  
СЭЛЭЛ



# АРХЕОЛОГИЙН СУДЛАЛ

XXX

УЛААНБААТАР  
2011

STUDIA ARCHAEOLOGICA  
INSTITUTI ARCHAEOLOGICI  
ACADEMIAE SCIENTIARUM MONGOLICAE

Tomus XXX

2011

Fasciculus 1-14

# АРХЕОЛОГИЙН СУДЛАЛ

Эрхэлсэн: Доктор, дэд профессор Ц.Төрбат

УЛААНБААТАР  
2011

DDC  
930.1'015'517  
А-779

ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн  
Эрдмийн зөвлөлийн баталснаар хэвлэв.

## РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ:

Ерөнхий редактор: доктор (Sc.D), профессор Д.Цэвээндорж  
Гишүүд: (Цагаан толгойн үсгийн дарааллаар)  
доктор (Ph.D), дэд профессор Ч.Амартүвшин  
доктор (Ph.D), профессор Б.Гүнчинсүрэн  
доктор (Ph.D), дэд профессор Ц.Төрбат  
доктор (Ph.D), дэд профессор Б.Цогтбаатар  
доктор (Ph.D), дэд профессор Я.Цэрэндагва  
доктор (Ph.D) У.Эрдэнэбат  
доктор (Ph.D) Г.Эрэгзэн

## АРХЕОЛОГИЙН СУДЛАЛ

Боть ХХХ, Дэвтэр 1-14, Улаанбаатар хот, 2011 он.

Эрхэлсэн: Доктор (Ph.D), дэд профессор Ц.Төрбат  
Хэвлэлд бэлтгэсэн: Эрдэм шинжилгээний ажилтан, докторант Ж.Гантулга  
Макет дизайн: Ц.Наранбат

“Профото дизайн” ХХК-д хэвлэв

ISBN : 978 - 99962 - 1 - 229 - 1

## ГАРЧИГ

- 5 Я.Цэрэндагва, Ж.Гантулга, Ж.Магайл. Хойд Тамирын голын хөндийн чулуун зэвсгүүд
- 21 С.А.Гладышев, Б.Гүнчинсүрэн, Е.П.Рыбин, А.В.Табарев, Ц.Болорбат, Д.Одсүрэн, Д.Олсен. 2010 онд хуучин чулуун зэвсгийн олон соёлт давхарга бүхий Төлбөр-15 дурсгалт газарт хийсэн судалгааны үр дүн
- 51 С.А.Гладышев, Б.Гүнчинсүрэн, А.Н.Попов, А.В.Табарев, Ц.Болорбат, Д.Одсүрэн. Их Төлбөрийн голын хөндий дэх чулуун зэвсгийн шинэ дурсгал
- 65 Д.Цэвээндорж. Монголын эртний цанын тухай
- 69 Я.Бемманн, Б.Аренс, К.Грүцнер, Р.Клингер, Н.Клицш, Ф.Леманн, С.Линзен, Л.Мөнхбаяр, Г.Номгуунсүрэн, М.Опчипка, Х.Пиезонка, Б.Шүгт, С.Саран. Тал нутгийн Геоархеологи - Төв Монгол - Орхоны хөндийд хийгдэж буй Монгол-Германы хамтарсан шинжлэх ухааны олон төрлийн судалгааны эхний үр дүн
- 98 Н.Батболд. Хадны зосон зураг дахь сөөлжир чагтан тэмдгийн утга санааг тайлбарлах нь
- 107 Ц.Төрбат, Д.Батсүх, Н.Баярхүү, П.-Х.Жискар. Харганатын гол ба Сыргалийн талын Пазырыкийн үеийн булшнууд (Судалгааны урьдчилсан үр дүн)
- 139 Т.Осава, К.Сүзүки, Г.Лхүндэв. Заамарын Шороон довоос олдсон мөнгөн саван дээрх руни бичээс
- 146 У.Эрдэнэбат, З.Батсайхан, Б.Дашдорж, Ч.Амарбилэг. Архангай аймгийн Хотонт сумын нутаг Олон дов хэмээх газар 2010 онд хийсэн археологийн шинжилгээ
- 186 А.Энхтөр, И.Үсүки, Ё.Сэнда, М.Сагава, Г.Батболд, Ц.Буянхишиг, Д.Отгон. Чинтолгойн балгасны ваар сав шатаах зуухны малтлага судалгааны урьдчилсан үр дүн
- 200 Ш.Баатар, У.Эрдэнэбат. Хөхнуурын Цайдамаас олдсон монгол баатрын занданшсан шарил
- 218 Ш.Баатар. Монголын Их Юань улсын төрийн бэлгэдэл таван нүдэн
- 233 С.Хүрэлсүх, Ц.Амгалантөгс, Б.Фролич. Баянхонгор аймгаас олдсон хадны оршуулгууд
- 243 Р.Эрдэнэцэцэг, Руй Дунг Ван, Ганг Су Ёнг. Археологийн хүрээлэнгийн сан хөмрөгт буй зарим төмөр эдлэлийг сэргээн засварласан ажлын үр дүнгээс
- 256 ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн 2010 оны хээрийн судалгааны ажил болон зохион байгуулсан хурал, үзэсгэлэн
- 266 Түүхийн шинжлэх ухааны доктор, профессор Юлий Сергеевич Худяков
- 283 Эмгэнэл: Монгол улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, шинжлэх ухааны доктор, профессор Довдойн Баяр (1946-2010)
- 302 Зохиогчдын танилцуулга
- 308 Шинэ номын танилцуулга

CONTENT

- 5 **Ya.Tserendagva, J.Gantulga, J.Magail.** Stone tools of Khoid Tamir valley
- 21 **S.A.Gladyshev, B.Gunchinsuren, E.P.Rybin, A.B.Tabarev, Ts.Bolorbat, D.Odsuren, J.Olsen.** Results of the study of multilayered Paleolithic site Tulber-15 in 2010
- 51 **S.A.Gladyshev, B.Gunchinsuren, A.N.Popov, A.V.Tabarev, Ts.Bolorbat, D.Odsuren.** New Stone Age sites in the valley of Tulberyn gol, North Mongolia
- 65 **D.Tseveendorj.** About the ancient ski of Mongolia
- 69 **J.Bemmann, B.Ahrens, C.Grützner, R.Klinger, N.Klitzsch, F.Lehmann, S.Linzen, L.Munkhbayar, G.Nomguunsuren, M.Oczipka, H.Piezonka, B.Schütt, S.Saran.** Geoarchaeology in the steppe first result of the multidisciplinary Mongolian – German survey project in the Orkhon valley, Central Mongolia
- 98 **N.Batbold.** Explaining the meaning of slanting cross marks in the rock paintings
- 107 **Ts.Turbat, D.Batsukh, N.Bayarkhuu, P.-H.Giscard.** Kharganat Gol and Syrgal steppe Pazyryk kurgans (Preliminary results)
- 139 **T.Osawa, K.Suzuki, G.Lkhundev.** A newly discovered Runic inscription engraved on a silver vessel from Zaamar soum
- 146 **U.Erdenebat, Z.Batsaikhan, B.Dashdorj, Ch.Amarbileg.** Archaeological research in Olondov site of Khotont soum, Arkhangai province /2010/
- 186 **A.Enkhtur, I.Usuki, Yo.Senda, M.Sagawa, G.Batbold, Ts.Buyankhishig, D.Otgon.** A preliminary result of pottery kiln excavation at the Chintolgoi ruin
- 200 **Sh.Baatar, U.Erdenebat.** Mongolian warrior's mummy excavated in the Tsaidam area of the Qinhai province, China
- 218 **Sh.Baatar.** The five-eye is the state symbol of the Greater Mongolian Yuan Empire
- 233 **S.Khurelsukh, Ts.Amgalantugs, B.Frohlich.** Newly discovered cave burials of Bayankhongor aimag
- 243 **R.Erdenetsetseg, Ryu Dong-wan, So-Yeong Kang.** Conservation and restoration works on some iron objects preserved in the laboratory of Institute of Archaeology
- 256 **Field research, conferences and exhibitions in 2010**
- 266 **Doctor, professor Yulii Sergeevich Hudyakov**
- 283 **Necrology; Doctor, professor [D.Bayar] (1946-2010)**
- 302 **Authors**
- 308 **New books**

Я.ЦЭРЭНДАГВА, Ж.ГАНТУЛГА, Ж.МАГАЙЛ

ХОЙД ТАМИРЫН ГОЛЫН ХӨНДИЙН  
ЧУЛУУН ЗЭВСГҮҮД

**Товчлол**

Энэхүү өгүүлэлд Архангай аймгийн Их Тамир сумын нутаг Хойд Тамирын голын сав нутгаас олдсон хуучин чулуун зэвсгийн талаар өгүүлнэ.

**Түлхүүр үгс**

Монгол улс, чулуун зэвсэг, Архангай, Их Тамир сум, Хойд Тамирын гол, Цац толгой, Хөрөөгийн үзүүр

**Удиртгал**

Хойд Тамирын голын хөндий бол нэн эртнээс дундад зууны түүхэнд холбогдох арвин их дурсгалуудыг хадгалан үлдсэн нутгийн нэг билээ. Энэ сав нутгийн эртний түүх, соёлын дурсгалуудыг аль XIX зууны сүүл үеэс сонирхон судлаж ирсэн бөгөөд өнөөдөр ч судалгаа үргэлжлэн хийгдсээр байна.

Хойд Тамирын голын сав дагууд хуучин чулуун зэвсгийн зүйлс хэд хэдэн газраас олддог тухай судлаачид дурдсан байдаг ч тусгайлан нийтлүүлсэн нь ховор юм.

Харин бид энэ удаад 2006 оноос эхлэн Хойд Тамирын голын сав нутаг тэр дундаа Цац толгой, Цацын эрэг, Баянцагааны хөндий, Хөрөөгийн үзүүр орчмын хүрэл, төмөр зэвсгийн түрүү үеийн цогцолбор дурсгалт газар судалгаа хийж байгаа Монгол-Монакогийн хамтарсан археологийн хээрийн шинжилгээний ангийн түүвэрлэсэн чулуун зэвсгийн зүйлсийг судалгааны эргэлтэнд оруулан нийтэлж байна.

Эдгээр чулуун зэвсгийн талаар өгүүлэхээс өмнө уг голын сав нутагт чулуун зэвсгийн судалгааг хэрхэн хийж ирснийг тоймлон авч үзье.

Анх 1955-1957 онуудад Монголын ууган археологичдын нэг Ц.Доржсүрэн Тайхар чулуу болон Алтансандал уулын орчмоос чулуун зэвсгийн зүйлс түүвэрлэн цуглуулж судлаачдын сонорт хүргэсэн байна [Доржсүрэн 1957: 49-50; 1958].

Үүний дараагаар 1960-1966 онд А.П.Окладников, В.Е.Ларичев, Д.Дорж нарын эрдэмтэд манай улсын бараг бүх аймгийн нутгийг хамарсан хайгуул судалгаа явуулж, хуучин чулуун зэвсгийн дунд, дээд үе болон шинэ чулуун зэвсгийн дурсгал олон газраас илрүүлсний нэгд Тамирын голын сав нутаг дахь Тайхир чулуу орчим [Окладников, Ларичев 1963: 81; МУТ 2003: 15] багтана.

Мөн 1968 онд Тажикистаны чулуун зэвсэг судлаач В.А.Ранов Хойт

Тамирын голын хөндийгөөр хайгуул хийж Их Тамир сумын төвийн орчмоос олон тооны чулуун зэвсгийн дурсгал илрүүлэн олсон байна [Ранов 1971: 1974].

1975 онд МЗТСХЭ-ийн палеолит ба нүүдэлчдийн дурсгал судлах ангийнхан Их Тамир сумын төвөөс баруун хойш орших Шар булагийн Хужирт хэмээх газрын нарийн амнаас палеолитын үед хамаарч болохуйц чулуун эдлэл болон үлдэц хэдийг түүвэрлэжээ [Цэвээндорж 1975: 4].

1982 онд Д.Цэвээндорж, Р.С.Васильевский нарын удирдсан МЗТСХЭ-ийн чулуун зэвсгийн судалгааны анги Туул, Орхон, Урд, Хойд Тамир, Дэлгэр мөрний сав нутгийг хамарсан хайгуул судалгаа хийх явцдаа Хойт Тамирын голын хөндийн Эрдэнэ толгой, Харуул толгой, Элстэйн ам, Яргайт, Туулгайт, Бага улаан толгой зэрэг газруудаас нийт 12 газраас палеолит, неолитын үеийн баялаг хэрэглэгдэхүүн цуглуулсан [Васильевский 1982] байна.

2006 оноос эхлэн ажиллаж байгаа Монгол-Монакогийн судлаачид Цацын эрэг болон Хөрөөгийн үзүүр орчмоос цөөн тоотой боловч сонирхолтой чулуун зэвсгийн цуглуулгыг хийж чаджээ. Ингээд энэхүү сонирхолтой цуглуулгын талаар дор өгүүлье.

### Цац толгойн чулуун зэвсгийн дурсгал

Цац толгой бол Хойд Тамирын голын хойд талд орших боржин чулуун тогтоцтой өндөрлөг юм. Чулуун зэвсгийн зүйлс нь зөвхөн толгойн өвөр бэлээр тархсан байдалтай оршино.

2009 онд Цац толгойн энгэр бэлээс чулуун зэвсгийн зүйлс нийт 6 ширхэг олдсон нь ихэд өгөршин элэгдэж, өнгөр тогтсон байдалтай. Эдгээр нь үлдэц хэлбэрийн хагархай, хусуур зэвсэг, залтас, хавирган цуулдас, хоёр ялтсан цуулдас байна.

*Үлдэц хэлбэрийн хагархай.* 52,1 x 30,7 x 18,8 мм хэмжээтэй. Цохилтын нэг талбайт, цуулалтын нэг гадаргуут үлдэцтэй төстэй боловч чулууны өгөршлийн байдал нь бусад хийсэн арга барилын нарийн ажиллагааг тодорхойлоход хүндрэл учруулж байна (Зураг 2. 6).

*Хавирган цуулдас.* 49,8 x 26,4 x 14,9 мм хэмжээтэй. Хар саарал өнгийн цахиурлаг чулуугаар хийсэн (Зураг 2. 5).

*Хусуур.* 48 x 60,3 x 17,2 мм хэмжээтэй. Хар саарал өнгийн цахиурлаг чулуугаар хийсэн боловч байгаль, цаг уурын нөлөөгөөр гадаргуу дээр нь цагаан өнгийн өнгөр тогтжээ. Хусуурыг залтас ашиглан хийсэн бөгөөд урт нэг талын ирмэгийн хэсэгхэн газрыг холтчин эгцдүү байдлаар ирлэжээ. Элэгдэлийн улмаас ирлэсэн байдал нь тодорхой мэдэгдэхгүй байна. Мөн нөгөө талын дугуйрсан хэсэгт хоёр уртавтар хэлтлэлт хийжээ (Зураг 2. 1).

*Ялтсан цуулдас.* 28,8 x 15,8 x 8,2 мм хэмжээтэй. Хар саарал өнгийн цахиурлаг чулуун хоёр талстат ялтсан цуулдас. Ирмэг хөвөөгөөр нь ганц нэгхэн хожуу гарсан хэлтлэлт ажиглагдана. Цохилтын талбайн үлдэгдэл нь хөндлөн холточмол юм (Зураг 2. 2).

*Ялтсан цуулдас.* 26,2 x 16,7 x 9,8 мм хэмжээтэй. Хар саарал өнгийн цахиурлаг чулуун хоёрдогч ялтсан цуулдас. Цохилтын талбайн үлдэгдэл нь гөлгөр (Зураг 2. 3).

*Залтас.* 25,5 x 23,9 x 5,5 мм хэмжээтэй. Гадна талд нь өмнөх цуулалтуудын ормыг хадгалсан. Цохилтын талбайн үлдэгдэл нь шулуун, гөлгөр (Зураг 2. 4).

2010 онд Цац толгой орчмоос 24 ширхэг чулуун зэвсгийн зүйлс

цуглуулсныг төрөлжүүлэн ангилан авч үзвэл 2 үлдэц, 1 үлдэц хэлбэрийн хагархай, 3 цоолтуур, 2 хянгар, 3 шүдлэг хүнхэр иртэй зэвсэг, 1 цуулдас, 7 залтас, 2 ялтас, 2 хагархай тус тус байна.

**Анхдагч цуулалт.** Энэ хэсэгт үлдэц, бэлдэц, үлдэц хэлбэрийн хагархай хамаарч байна.

Нийт хоёр үлдэц байгаа ба эхний үлдэц нь цохилтын нэг талбайт, цуулалтын нэг гадаргуутай. Түүнийг саарал өнгийн чулуугаар хийжээ. Урдаасаа болон хөндлөн огтлолоороо гурвалжиндуу хэлбэртэй. Цохилтын талбай нь тэгшхэн. Цуулалтын гадаргуу дээр нэг урт ялтсан болон хэд хэдэн жижиг залтсан цуулалтын ором хадгалагдан үлджээ. Цохилтын талбайн ирмэгээр олон тооны цуулалт хийх гэж оролдсон хагарал хортонгууд үүссэн. Энэ нь цуулалт хийх гэж олон оролдсон ч тухай бүрт бүтэлгүй болж байсныг харуулж байгаа явдал юм. Мөн зүүн хажуугаас ар тал руу хөндлөн хэд хэд хүчтэй цохиж хагалсан ором тод үлджээ. Хэмжээ: 55 x 61 x 48 мм (Зураг 2. 7). Хоёрдахь үлдэц нь шаантган үлдэц байна. Саарал өнгийн цахиуржсан чулуугаар хийжээ. Цохилтын талбай нь ганц цохилтоор үүссэн ба хажуу тийшээ налуувтар. Цуулалтын гадаргуу дээр хоёр хутган бичил ялтас авсан ором ажиглагдана. Суурь хэсгийг шовхолж, ар талыг хоёр талаас сайтар ирлэж засчээ. Зүүн хажууг дээрээс, баруун хажууг хөндлөн засч бэлтгэсэн байна. Хоёр хажуу нь тэгшхэн. Хэмжээ: 29 x 0,9 x 24 x мм (Зураг 2. 9).

*Үлдэц хэлбэрийн хагархай.* Бор шаргал өнгийн элсэн чулуугаар хийсэн. Түүний бүх гадаргуу нь замбараагүй цуулалтын ормыг хадгалжээ. Хэмжээ: 45 x 44 x 26 мм.

**Багаж зэвсэг.** Нийт зэвсгийн зориулалттай есөн эдлэл байна. Тэдгээрийн тоонд хянгар, хусуур, цоолтуур, шүдлэг хүнхэр иртэй зэвсгүүд багтана.

*Хянгар.* Энэ зэвсгийг баргил том саарал өнгийн цахиурлаг залтасаар хийжээ. Нэг ирмэгийг гүдийлгэн зэрэгцээ байдлаар хагалан ирлэж босоодуу ир гаргажээ. Хэмжээ: 45 x 62 x 25 мм (Зураг 2. 8).

*Хусуурыг* бор саарал өнгийн элсэн чулуун хоёрдогч залтасаар хийжээ. Нарийн болон урд хоёр талыг тойруулан том жижиг, зэрэгцээдүү байдлаар ирлэж хагас босоо ир гаргажээ. 48 x 36 x 16 мм. Дараагийн хусуурыг баргил том анхдагч цуулдасаар хийсэн ба цохилтын талбайн эсрэг талын дугуй ирмэгийг тойруулан холтчин ирлэжээ. Хэмжээ: 76 x 55 x 24 мм (Зураг 2. 12).

*Шүдлэг хүнхэр иртэй зэвсэг.* Бор саарал өнгийн элсэн чулуун залтасаар хийсэн. Залтасны хоёр хажуугийн баруун талынхыг гадна талаас гурван удаа цохин хагалж шүдлэг хүнхэр ир гаргажээ. Эсрэг талыг нь мөн жижиг холтчин ир гаргажээ. 48 x 62 x 22 мм (Зураг 2. 13). Хоёрдахь зэвсгийг саарал өнгийн цахиурлаг чулуун залтасаар хийсэн ба нэг ирмэгийг хоёр хэсэг газар нилээн гүн хонхойлгон дотор талаас холтчин ирлэсэн байна. Хоёр хүнхэрийн дундах хэсэг нь шовх үзүүртэй болжээ. Хэмжээ: 47 x 36 x 19 мм (Зураг 2. 14). Сүүлийн зэвсгийг саарал өнгийн чулууны хагархайгаар хийсэн ба өргөн талын ирмэгийг хоёр газар хонхойлон холтчин ирлэж голыг нь шовхлон шүд гаргажээ. Энэхүү шүд нь нэг талаар цоолтуур болон өрөмний ирэн хэсгийг санагдуулна. Хэмжээ: 50 x 39 x 25 мм (Зураг 2. 15).

*Цоолтуур.* Эхний цоолтуурыг саарал өнгийн цахиурлаг чулуун зузаан залтасаар хийсэн байна. Түүний нэг үзүүрийг хоёр талаас нь уулзуулан хоёр том холтлон авч хурц үзүүр гаргажээ. Хэмжээ: 41 x 26 x 16 мм (Зураг

2. 10). Дараагийн цоолтуурыг саарал өнгийн нимгэн залтасаар хийсэн ба нэг талын буланг хоёр талаас нь цавчин өөлж шовх үзүүр гаргасан байна. Эдэлгээний явцад энэхүү шовх үзүүр нь мохож мөлийжээ. Хэмжээ: 30 x 30 x 0,7 мм (Зураг 2. 11). Сүүлийн цоолтуурыг мөн л саарал өнгийн цахиурлаг чулуугаар хийсэн байна. Түүний нарийн шовх үзүүрийг бага зэрэг холтлон засч янзлан цоолтуур болгосон байна. Хэмжээ: 26 x 35 x 11 мм.

**Цуулдасны үйлдвэрлэл.** Энэ хэсэгт 7 залтас, 2 ялтас, 1 ялтсан залтас хамаарч байна.

*Залтасууд* хэмжээ болоод хэлбэрийн хувьд харилцан адилгүй юм. Хоёр нь хоёрдогч залтас. Таван залтасны талбайн үлдэгдэл гөлгөр. Хоёрынх нь холточмол. Нэг залтасны ирмэгээр жигд бус ир ажиглагдана. Хэмжээний хувьд хамгийн том нь 56 x 52 x 20 мм., жижиг нь 18 x 24 x 0,5 мм байна (Зураг 2. 16-18).

*Хоёр ялтас бүтэн.* Хэмжээний хувьд харилцан адилгүй. Нэг нь хоёр талт, нөгөө нь гурван талтай. Эхний баргил ялтасны доод үзүүр ормыг хүнхийлгэн нэлэнхүйд нь ирлэсэн байдал харагдана. Хэмжээ: 59 x 30 x 22 мм. Хоёрдахь нь нимгэн хоёр хажуугийн ирмэгээр хожим гарсан жижиг ирүүд мэдэгдэм төдий юм. Хэмжээ: 40 x 24 x 0,5 мм.

*Ялтсан залтас.* Хэмжээний хувьд жижиг, нимгэн. Хэмжээ: 24x20x0,4 мм.

*Хагархай.* Цуулалтын ором бүхий саарал өнгийн хагархайнууд хоёр байна. Хэмжээ: 49 x 43 x 27 мм, 50 x 36 x 31 мм.

### Хойд Тамирын голын хойд эргийн чулуун зэвсэг

Харин Хойд Тамирын голын хойд эргээр чулуун зэвсгийн зүйлс маш ховор боловч сонин хэлбэр хийцтэй ганц зэвсэг олдсон юм. Энэ нь чоппер маягийн зэвсэг байна.

**Чоппинг маягийн зэвсэг.** Хойд Тамирын голын хойд эргээс олдсон. 82,9 x 69,4 x 40,5 мм хэмжээтэй. Хар өнгийн нарийн ширхэгтэй алевролитон чулуугаар хийжээ. Эгц урдаасаа зүрхэн хэлбэрийн, хөндлөн огтлолоороо ромбо хэлбэртэй. Чулууны өргөн үзүүрт нэг талаас нь 3 удаа нөгөө талаас нь 2 удаа ээлжлэн цохих замаар хурц долгио маягийн ир гаргажээ. Энэхүү ир ирмэг нэлээд хэмжээгээр холточлогдсон байгаа нь магадгүй удаан хугацаагаар хэрэглэж байсны баталгаа гэлтэй. Ир ирмэг, цуулалтын ором зэрэг нь дунд зэргийн элэгдэлд өртөж мөлийжээ. Ямар нэгэн чулуун зэвсгийн цуглуулгатай хамт бус, дангаар олдсон тул он цагийн хамаарлыг тодруулахад төвөгтэй. Гэсэн хэдий ч цуулалтын арга барил, элэгдлийн байдлаас нь үндэслэн дунд палеолитын үед хамааруулан авч үзэж болмоор байна (Зураг 3. 1).

### Хөрөөгийн үзүүрийн чулуун зэвсгийн дурсгал

Хөрөөгийн үзүүр бол Хойд Тамирын голын хойд эрэгт баруунаас зүүн тийш сунаж тогтсон хүрмэн чулуун тогтоцтой гүвээ-толгод юм. Чулуун зэвсгийн зүйлс нь толгодын өвөр бэлээр тархан оршино.

Хөрөөгийн үзүүрийн энгэр бэлээр орших булш, хиргисүүрийн ойр орчмоос нийт 62 ширхэг чулуун зэвсгийн зүйлс түүвэрлэн цуглуулсан нь дараах байдлаар ангилагдаж байна.

Анхдагч цуулалт:	Тоо
Бэлдэц	1
Үлдэц	5
Техникийн цуулдас	1
<b>Багаж зэвсэг:</b>	
Хусуур	4
Хусуур маягийн зэвсэг	1
Шүдлэг хүнхэр иртэй зэвсэг	1
Хүнхэр иртэй зэвсэг	1
Сийлүүр	3
Цоолтуур	3
Холтослуур	2
Хатгуур	1
Хосолмол зэвсэг	1
“Хамар” хэлбэрийн зэвсэг	1
Иртэй ялтас	1
<b>Цуулдасны үйлдвэрлэл:</b>	
Ялтас болон хугархай	4
Залтас	26
Сегмент хэлбэрийн цуулдас	2
Хагархай	4

*Бэлдэц.* Цагаан саарал өнгийн чулуугаар хийсэн шаантган үлдэц хийхээр бэлтгэн зассан бэлдэц. Цохилтын талбай болон шаантаг болгон суулгах суурь, ар талыг засаж бэлтгэжээ. Харин баруун хажууг нь засах явцад хэтэрхий гүн хагарч цаашид ашиглах боломжгүй болсон тул гүйцээлгүй орхижээ. Хэмжээ: 36 x 39 x 15 мм (Зураг 4. 4).

*Үлдэц.* Эхний үлдэц нь ногоон саарал өнгийн цахиуржсан чулуугаар хийсэн. Цохилтын нэг талбайт, цуулалтын нэг гадаргуутай. Цохилтын талбайг нь ар тийш налуулан хоёр зэрэгцээ цуулалтаар засч бэлтгэсэн. Цуулалтын гадаргуу дээр зэрэгцээ нарийн болон өргөн цуулалтын ором хадгалагджээ. Ар болон хоёр хажуу нь чулууныхаа өнгөн бүрхүүлээрээ байна. Суурь хэсгийг хэд хэдэн цуулалтаар засч тэгшилсэн ажээ. Хэмжээ: 51 x 60 x 33 мм (Зураг 3. 4).

Дараагийн үлдэц цохилтын нэг талбайт, цуулалтын нэг гадаргуутай. Ногоон шаргаддуу өнгийн цахиуржсан чулуугаар хийсэн, дөрвөлжиндүү хэлбэртэй. Цохилтын талбайг ар тийш налуулан хэд хэдэн угсараа цохилтоор бэлтгэсэн байна. Хоёр хажууг урд талаас нь хэд хэд цохиж бэлтгэжээ. Цуулалтын гадаргуу дээр зэрэгцээ өргөн нарийн цуулалтын ормууд халгалагдан үлдсэн. Сүүлд баруун хажуугаас дахин нэг залтас цуулан авсан байна. Хэмжээ 58 x 60 x 36 мм (Зураг 3. 2).

Гуравдахь үлдэцийг ногоон саарал өнгийн хайрган чулуугаар хийсэн, дөрвөлжиндүү хэлбэртэй. Цохилтын нэг талбайт, цуулалтын нэг гадаргуутай. Цохилтын талбай нь ганц цуулалтаар бэлтгэгдсэн, тэгшдүү хэлбэрийн, ар тийшээ налуувтар. Цуулалтын гадаргуу нь олон тооны ээлж дараалсан өргөвтөр цуулалтын ормуудыг хадгалжээ. Хамгийн сүүлийн хоёр цуулалт амжилтгүй болсон нь тод мэдэгдэнэ. Баруун хажууг нь хөндлөн тэгшлэн цохиж бэлтгэсэн байна. Эндээс цохилтын талбайг дахин цуулах оролдлого хийсэн ч бүтэлгүй болжээ. Ар талын гадаргуур баруун

хажуугаас зэрэгцээ урт хоёр цуулалтаар засч бэлтгэсэн. Зүүн хажуу, суурь, цуулалтын гадаргуугийн доод хэсэг чулууны өнгөн бүрхүүдээрээ байна. Хэмжээ: 40 x 58 x 47 мм (Зураг 3. 3).

Дөрөвдэх үлдэц нь тайрдсан хэлбэрийн төрөлд хамаарна. Цохилтын талбайг баруун тийш налуулан холтчин бэлтгэжээ. Хоёр хажууг хөндлөн болон тууш нэг нэг цуулалтаар бэлтгэсэн байна. Суурь хэсгийг нь шовхолхыг удаа дараа оролдсон нь илт мэдэгдэнэ. Цуулалтын гадаргуугаас хоёр нарийн бичил, нэг өргөн бичил ялтас цуулан авсан байна. хэмжээ: 39 x 20 x 27 мм (Зураг 3. 5).

Сүүлийн үлдэц цацраган цуулалтын зарчмаар бэлтгэгдсэн, зууван дугуйдуу хэлбэртэй. Нарийн талын нэг үзүүрийг холтчин тэгшдүү байдлаар засжээ. Бусад талаас нь төв рүү чиглэсэн цуулалт хийж цуулалтын гадаргууг бэлтгэсэн байна. Зассан тэгшдүү талаас олон тооны хэлтлэлт хийсэн боловч амжилтгүй болжээ. Ар талын гадаргууг мөн төв рүү чиглэсэн цацраган цуулалтаар засч бэлтгэсэн байна. Хэмжээ: 56 x 48 x 23 мм (Зураг 3. 6).

*Техникийн цуулдас.* Энэ цуулдас нь хавирган хэлбэртэй (Зураг 4. 11). Хар өнгийн цахиуржсан чулуугаар хийсэн. Хэмжээ 39 x 0,9 x 1,8 мм.

**Багаж зэвсэг.** Багаж зэвсгийн зориулалттай 20 эдлэл байгаагийн дотор хусуур, хусуур маягийн зэвсэг, цоолтуур, холтослуур, шүдлэг хүнхэр иртэй зэвсэг, хүнхэр иртэй зэвсэг, сийлүүр, хатгуур, залтас, иртэй залтас, хамартай зэвсэг тус тус байна.

*Хусуур* зэвсэг дөрвөн ширхэг байна. Эхний хусуурыг хавирган хэлбэртэй, ногоовтор өнгийн техникийн цуулдасаар хийсэн бөгөөд доод талын үзүүрийг нь хагас дугуйруулан эгц босоо байдлаар маш нарийн холтчин ирлэжээ. Хэмжээ: 57 x 18 x 10 мм (Зураг 4. 12). Хоёрдахь хусуурыг дөрвөлжиндүү хэлбэрийн саарал өнгийн залтасаар хийжээ. Залтасны доод тэгш үзүүрийг босоодуу холтчин ирлэсэн байна. Хэмжээ: 33 x 30 x 0,8 мм. Дараагийн хусуурыг хар саарал өнгийн залтас ашиглан хийжээ. Энэ хусуур нь шүдлэг хусуурын ангилалд хамаарна. Түүний эргэн тойрон хөвөөний 4/3-ийг нэг эгнээ, зэрэгцээ байдлаар налуулан том жижиг холтчин ирлэжээ. Нэг талын буланд нь цоолтуур зэвсгийнхтэй адил хурц үзүүр гаргасан байна. Хэмжээ: 38 x 39 x 16 мм (Зураг 3. 9). Сүүлийн хусуурыг хар өнгийн сегментэн цуулдсаар бэлтгэгдсэн. Түүний нэг талын буланг дугуйруулан холтчин ирлэжээ. Хэмжээ: 52,5 x 41 x 15 мм (Зураг 3. 12).

*Хусуур маягийн* зэвсгийг хар саарал өнгийн гурвалжиндуу залтас ашиглан үйлдэжээ. Түүний булантай талыг холтчин ирлэж хусуур маягийн ир гаргасан байна. 29 x 28,5 x 10 мм (Зураг 3. 11).

*Шүдлэг хүнхэр иртэй* зэвсгийг саарал өнгийн ялтасны хугархайгаар хийсэн ба түүний хоёр талыг гадна талаас нь хэлтлэн ирлэжээ. Хэмжээ: 37 x 29 x 15 мм (Зураг 4. 6).

*Хүнхэр иртэй* зэвсгийг саарал өнгийн залтас ашиглан хийжээ. Түүний хоёр хажуу талын нэгэнд гадна талаас нь хоёр зэрэгцээ байдлаар том жижиг ховил гарган хүнхэр ир бэлтгэсэн байна. Эсрэг талын гол хэсэгт мөн гадна талаас нь ганц ховил гаргажээ. Хэмжээ: 39 x 34 x 0,7 мм (Зураг 4. 8).

*Сийлүүр* зэвсэг гурав байна. Хоорондоо хэмжээний хувьд харилцан адилгүй ба эхний сийлүүрийг баргил ялтас ашиглан хийжээ. Ялтасны дээд талын зүүн буланд сийлүүрийн ирийг гаргасан байна. Эсрэг талын

ирмэгийг бага зэрэг холтчин ирлэсэн байх ажээ. Хэмжээ: 45 x 30 x 11 мм (Зураг 4. 1). Дараагийн сийлүүрийг бор өнгийн ялтасны хугархай ашиглан хийсэн байна. Түүний хугарсан хэсгийн буланд сийлүүрийн ирийг зэрэгцээ маягаар хоёр цохиж гаргажээ. Нөгөө ирмэгийг жижиг холтчин ирлэсэн байна. Хэмжээ: 22 x 19 x 0,5 мм (Зураг 4. 2). Гуравдахь сийлүүрийг саарал өнгийн ялтсан цуулдасаар хийсэн ба баруун дээд буланг уртааш цуулж сийлүүрийн ир гаргажээ. Хэмжээ: 32 x 1,5 x 0,9 мм (Зураг 4. 3).

*Цоолтуурын* нэгийг шаргал саарал өнгийн хагархай ашиглан хийжээ. Түүний нэг нарийн үзүүрийг нэг талаас нь сайтар холтчин засч шовхлон ирлэжээ. Хэмжээ: 55 x 43 x 37 мм (Зураг 3. 8). Хоёрдахь цоолтуурыг хар саарал өнгийн сегментэн цуулдасаар хийсэн байна. Цуулах явцад гарсан шовх үзүүрийг нэг талаас нь бага зэрэг нарийн ир гарган үзүүрлэжээ. Хэмжээ 49 x 32 x 16 мм (Зураг 4. 10). Дараагийн цоолтуурыг хар өнгийн цахиурлаг чулууны хагархайгаар хийсэн байна. Нэг үзүүрийг хоёр талаас нь цуулан өөлж нарийн шовх үзүүр гаргажээ. Хэмжээ: 44 x 32 x 20 мм (Зураг 4. 5).

*Холтослуур* зэвсэг хоёр байна. Эхнийхийг хөх саарал өнгийн цахиурлаг дунд зэргийн хэмжээтэй залтасаар хийсэн байх ба түүний доод үзүүрийн өргөн ирмэгийн үзүүр хэсгийг дотор талаас нь холтчин нэг үзүүрийг шовхолжээ. Уг шовх үзүүртэй залгуулан хүнхэр ховил гарган нарийн ирлэсэн байна. Хэмжээ: 30 x 24 x 10 мм (Зураг 3. 14). Дараагийн холтослуурыг хар саарал өнгийн дунд зэргийн залтас ашиглан хийхдээ түүний нэг хажууг гадна талаас нь хүнхийлгэн ир гаргажээ. Хэмжээ: 29 x 25 x 0,8 мм (Зураг 3.15).

*Хатгуур* зэвсгийг ногоовтор өнгийн жижиг залтасаар хийсэн байна. Хатгуур үзүүрийг залтасны доод үзүүрт хоёр талаас нь өөлөн цуучих замаар гаргажээ. Хэмжээ: 18 x 25 x 0,7 мм (Зураг 4. 9).

*Хосолмол* зэвсэг нь хусуур болон сийлүүрийн бүрдэл болсон зэвсэг байна. Том хэмжээний хар саарал өнгийн залтас ашиглан хийхдээ доод үзүүрийн ирмэгийг дугуйруулан хусуурын ир гаргажээ. Цохилтын талбайн үлдэгдлийн баруун талын буланг хэд хэд уртааш хагалан цохиж сийлүүрийн ир гаргасан байна. Хэмжээ: 52 x 41 x 14 мм (Зураг 3. 13).

Саарал өнгийн хайрган чулууны хагархайгаар хийсэн өрөмөрхүү “хамар хэлбэрийн” зэвсэг нэг байна. Энэ зэвсгийн нэг талыг том хагалж нарийн үзүүр гаргаад түүнийгээ нөгөө талаас нь уртааш дахин цуулан хамар маягийн догол гаргажээ. Хэмжээ: 50 x 39 x 24 мм (Зураг 3. 10).

*Иртэй ялтас.* Хоёр талт ялтасны нэг талын урт ирмэгийг том жижиг, хайнгадуухан холтослон ирлэжээ. Доод үзүүрийг нь ташуудуу хагалсан нь сийлүүрийг бас санагдуулна. Хэмжээ: 48 x 22 x 0,6 мм (Зураг 4. 7).

**Цуулдасны үйлдвэрлэл.** Ялтаснууд хэмжээ болон хэлбэрийн хувьд хоорондоо адилгүй, нэг нь бүтэн, гурав нь хугархай. Бүтэн ялтасны хувьд хоёр талтай. Дээд үзүүрийн баруун буланг уртааш хагалжээ. Цохилтын талбайн үлдэгдэл нь гүдгэр хэлбэртэй, холточмол. Хэмжээ: 48 x 28 x 13 мм. Гурван хугархай нь гурвуул дээд хэсгийн хугархай байна. Хоёр нь гурван талт, нэг нь хоёр талт юм. Хоёрынх нь цохилтын талбайн үлдэгдэл холточмол, нэг нь налуу ажээ. Хэмжээ нь 46 x 25 x 0,8 мм, 52 x 23 x 12 мм, 19 x 20 x 0,4 мм.



*Залтас болон цуулдасууд.* Нийт 26 ширхэг залтас, цуулдас байна. Тэдгээрийн нэг нь анхдагч цуулдас, долоо нь хоёрдогч цуулдас, үлдсэн нь ердийн залтас байна.

Анхдагч цуулдасын хэмжээ: 60 x 35 x 17 мм (Зураг 4. 14).

*Хоёрдогч цуулдасууд* бүгд дунд зэргийн хэмжээтэй. Долоон цуулдасны цохилтын талбайн үлдэгдэл нь гөлгөр, нэгнийх нь хайрган. Хэмжээний хувьд 41 x 30 x 16 мм - 30 x 22 x 10 мм-ийн хооронд хэлбэлзэнэ.

*Залтасууд* хэмжээ болоод хэлбэрийн хувьд харилцан адилгүй. Тэдний гадаргуу дээр олон тооны замбараагүй өмнөх цуулалтын ормууд хадгалагджээ. Хамгийн том нь 50 x 52 x 17 мм бол жижиг нь 12 x 14 x 0,9 мм ажээ. Арван залтасны цохилтын талбайн үлдэгдэл гөлгөр, дөрвийнх холточмол, хоёрынх хоёр талт гүдгэр байна. Харин хоёр залтасных мэдэгдэхгүй болжээ (Зураг 4. 15-19).

*Сегмент хэлбэрийн цуулдас.* Эхний цуулдасыг шар өнгийн хайргаар хийсэн байна. Эргэн тойрны ирмэгийн 3/2 нь чулууны өнгөн бүрхүүл хэвээр байна. Өргөн талын доод ирмэгийг ирлэх оролдлого хийжээ. Хэмжээ: 34 x 56 x 19 мм. Дараагийн цуулдас хар өнгийн цахиуржсан чулуунаас цуулж авсан. Гадна талд нь өмнөх замбараагүй цуулалтуудын ором хадгалаастай. Хэмжээ: 36 x 50 x 15 мм (Зураг 4. 13-14).

*Хагархайнууд.* Нийт дөрвөн хагархай байна.

### **Чулуун зэвсэг хийсэн арга барил, он цаг, харилцан хамаарлын асуудал**

Хойт Тамирын голын хөндийгөөс олдсон дээрх чулуун зэвсгийн дурсгалууд хэдийгээр тооны хувьд цөөн боловч чулуун зэвсгийн үйлдвэрлэлийн шинж байдал, цуулалтын арга зэргийг тодруулан авч үзэж болох нь харагдаж байна. Хэдийгээр дээрх чулуун зэвсгүүд соёлт давхаргаас бус, газрын өнгөн хөрсөн дээрээс ил байдалтайгаар олдсон тул он цагийн хамааралыг тодруулахад төвөгтэй хэдий ч хийсэн арга барил, багаж зэвсгийн шинж төлөв, элэгдэл өгөршлийн байдал зэрэгт дулдуйдан хамаарах он цагийн асуудлыг улиралуулан тодруулах боломжтой юм.

Хамгийн сонирхол татаж байгаа олдвор нь чоппинг маягийн зэвсэг юм. Энэ зэвсгийг хар өнгийн нарийн ширхэгтэй алевролитон чулуугаар хийжээ. Чулууны өргөн үзүүрт нэг талаас нь 3 удаа нөгөө талаас нь 2 удаа ээлжлэн цохих замаар хурц долгио маягийн ир гаргажээ. Уг зэвсгийг удаан хэрэглэж байсан нь түүний ирэн талд гарсан олон тооны хортонгуудаас тод харагдана. Хэдийгээр чоппинг зэвсэг нь доод палеолитыг илэрхийлэх гол зэвсгийн нэгэд тооцогддог боловч бидний гарт байгаа зэвсэг харьцангуй хожуу үед холбогдох магадлалтай юм. Элэгдэл өгөршлийн хувьд дунд зэрэг. Цуулалтын арга барил, элэгдлийн байдал, уг зэвсгийн үндсэн үүрэг зэргээс нь авч үзэхэд дунд палеолитын үед хамааруулан авч үзэж болмоор байна.

Цац толгойн хувьд авч үзвэл 2009 онд 6, 2010 онд 24 ширхэг чулуун зэвсгийн зүйл түүвэрлэсэн ба эдгээр цуглуулгын анхдагч цуулалтын байдлыг харахад цохилтын нэг талбайт, цуулалтын нэг гадаргуут болон шаантган үлдэц байгаа ба энэ хоёроос хожуулангаас нь ялтас цуулан авсан байна. Эндээс харахад хэдийгээр хоёрхон үлдэцэд тулгуурлан анхдагч

цуулалтын төлөв байдлыг гаргахад хэдий төвөгтэй ч ялтас цуулан авч зэвсэг хийх арга байсныг харж болно.

Багаж зэвсгийн хувьд цоолтуур, шүдлэг хүнхэр иртэй зэвсэг, хусуур голлох ба ганц хянгар байна.

Хөрөөгийн үзүүрийн чулуун зэвсгийн дурсгалын анхдагч цуулалтын байдлыг харахад цохилтын нэг талбайт, цуулалтын нэг гадаргуут үлдэцээс зэрэгцээ цуулалтын аргаар залтас, ялтас цуулан авсан байдал харагдана. Мөн ялтас цуулан авах цацраган цуулалтын арга хэрэглэж байжээ.

Багаж зэвсгийн хувьд хусуур, цоолтуур зэвсгүүд бусдаас олон байгаа ба сийлүүр, холтослуур зэвсэг тус бүр хоёр, шүдлэг хүнхэр иртэй зэвсэг, хүнхэр ирт зэвсэг, хатгуур, хосолмол зэвсэг, хамартай зэвсэг, ирлэсэн ялтас ганц ганц байх ажээ.

Цуулдасны үйлдвэрлэл буюу чулуу хийх явцад гарсан хаягдал хэсэгт залтас үнэмлэхүй давамгайлах ба ялтас, хагархай цөөн боловч байна.

Цац толгой, Хөрөөгийн үзүүрийн дээрх хоёр бууцны чулуун зэвсгийн үйлдвэрлэлийн арга нь хоорондоо адил төстэй нь шууд харагдахын дээр чулуун зэвсэг хийсэн арга барил, анхдагч цуулалт, багаж зэвсгийн байр байдал зэргээс харахад дээд палеолитын үед холбогдмоор ажээ. Учир нь анхдагч цуулалтад бичил үлдэцийн эртний хэлбэр болон зэрэгцээ цуулалтын арга голлож байна. Мөн багаж зэвсгийн цуглуулгад сийлүүр, хусуур, цоолтуур зэрэг дээд палеолитын голлох зэвсгүүд байгаа нь холбогдох он цагийг торуулах гол хэрэглэгдэхүүн боллоо. Дээрх хоёр дурсгалт газрын чулуун зэвсгийн дотор багаж зэвсгийн чанартай эдлэлүүд олон тоотой байгаа нь тухайн газарт палеолитын үеийн хүмүүс түр хугацаагаар буудаллан амьдарч байсан бууц болохыг нотлон харуулна.

Бидний нийтлүүлэн буй дээр дурдсан хоёр бууц нь урьд өмнө Хойт Тамирын голын хөндийгөөс олдож байсан бууц суурингийн чулуун зэвсгийн дурсгалуудтай бүхий л талаараа адилсахын дээр Мойлтын ам, Орхон-1, Орхон суурины дээд палеолитын үеийн олдвор хэрэглэгдэхүүнтэй хийсэн арга барил, хэв шинжийн хувьд ижилсэж байна. Харин чоппер маягийн зэвсгийн хувьд бусдаас тод ялгарах ба Мойлтын амны суурингийн доод давхаргаас олдсон чоппинг зэвсгүүдтэй ойролцоо арга барилаар хийгджээ.

Ya.Tserendagva, J.Gantulga, J.Magail

Ном зүй

**Stone tools of Khoid Tamir Valley**

This article narrate about the stone tools which founded by Mongol-Monaco joint expedition from the Khoid Tamiryn gol site.

Although the quantities of above stone tools of Khoid Tamiryn gol site are counted in a few numbers, but possible to study their type of stone tool productivity and chipping techniques. It is complicated to determine the concerning date when stone tools have been found from the surface, instead of cultural layer. However, there is a possibility to identify the chronology by their making technique, tool type and erosion.

The most spectacular finding was a chopping type tool. This tool made from fine-grained siltstone (aleurolite). Although the chopping is considered as one of main representative of the lower Paleolithic, the stone tools on our hands has a probability to relate to the later period. Erosion-weathering is average. According to the chipped technique, erosion, and main purpose, it is possible to concern to the middle Paleolithic age.

The manufacturing method of above campsites of the Tsats tolgoi and Khuru-ugyn uzuur are certainly similar and its technique, initial chipping and condition is probably related to the Upper Paleolithic period, prevailing the ancient style of initial chipped micro-cores and also bifacial chipping method. The burin, scraper and picker, which were among the tool collection, have been used as the main materials to identify the chronology. A large number of the weapon and tool stones among the stone tools which have been found from above two sites are proves that these sites were the campsites of Paleolithic people who resided there for a for a time.

Above stated two campsites are similar by all things with the stone tools of settlements and campsites which have been found earlier from the Khoid Tamiryn gol site and also similar to making techniques and types of Paleolithic findings of the Moiltyn am, Orkhon-1 and Orkhon sites of Upper Paleolithic. The chopper style of tools are very different from other tools and made by identical technique of chopping tools of the Moiltyn am sites` lower layer.

**Васильевский Р.С.** Археологические работы в Монголии в 1982 году. // Известия Сибирского отделения Академии наук СССР. № 6, вып. 2. 1983.

**Доржсүрэн Ц.** 1956-1957 онуудад Архангай аймагт археологийн шинжилгээ хийсэн нь. УБ., 1958.

**Доржсүрэн Ц.** БНМАУ-ын нутаг дахь чулуун зэвсэг судлалын байдал. УБ., 1957.

**Монгол улсын түүх,** Монгол улсын түүх. Боть I, УБ., 2003.

**Монгол-Монакогийн хамтарсан ...**, Монгол-Монакогийн хамтарсан археологийн хээрийн шинжилгээний ангийн 2009 оны ажлын тайлан. Улаанбаатар, 2009, АХБГС.

**Монгол-Монакогийн хамтарсан ...**, Монгол-Монакогийн хамтарсан археологийн хээрийн шинжилгээний ангийн 2010 оны ажлын тайлан. Улаанбаатар, 2010, АХБГС.

**Окладников А.П., Ларичев В.Е.** Археологические исследования в Монголии в 1961-1962 гг. // Известия Сибирского отделения Академии Наук СССР. № 1, Вып. 1, Новосибирск. 1963, стр. 78-89.

**Ранов В.А.** Научная командировка в Монголию. // Изв. АН Тадж. ССР. Отд. обществ, наук. 1971. № 2 (64).


**Ранов В.А.** Остатки стоянок каменного века у сомона Их-Тамир (Монголия) и некоторые вопросы изучения палеолита Центральной Азии. // ДИНЮВС. Иркутск, 1974. Вып. 2, стр. 35-53.

**Цэвээндорж Д.** 1975 онд МЗТСХЭ-ийн Булган, Хөвсгөл, Увс, Архангай, Баянхонгор аймагт ажилласан палеолит ба нүүдэлчдийн дурсгал судлах ангийн тайлан. УБ., 1975, АХБГС.



## Хавсралт-1

## Хойд Тамирын голын сав нутгаас түүвэрлэсэн чулуун зэвсгийн талаархи товч мэдээллийн хүснэгт


№	Чулуун зэвсгийн зүйлс	Дурсгалт газрын нэрс		
		Цац толгой	Хөрөөгийн үзүүр	Хойд Тамирын гол
<b>Анхдагч цуулалт</b>				
1	Бэлдэц	-	1	-
2	Үлдэц	2	5	-
3	Үлдэц хэлбэрийн хагархай	2	-	-
4	Техникийн цуулдас	-	1	-
<b>Багаж зэвсэг</b>				
1	Чоппинг маягийн зэвсэг	-	-	1
2	Хусуур	2	4	-
3	Хусуур маягийн зэвсэг	-	1	-
4	Шүдлэг хүнхэр иртэй зэвсэг	3	1	-
5	Хүнхэр иртэй зэвсэг	-	1	-
6	Сийлүүр	-	3	-
7	Цоолтуур	3	3	-
8	Холтослуур	-	2	-
9	Хаггуур	-	1	-
10	Хосолмол зэвсэг	-	1	-
11	Хамар хэлбэрийн зэвсэг	-	1	-
12	Иртэй ялтас	-	1	-
13	Хянгар	2	-	-
<b>Цуулалтын үйлдвэрлэл</b>				
1	Залтас болон цуулдас	-	26	-
2	Анхдагч цуулдас	-	-	-
3	Хоёрдагч цуулдас	-	-	-
4	Залтас	8	-	-
5	Ялтас	2	4	-
6	Ялтсан залтас	1	-	-
7	Ялтсан цуулдас	2	-	-
8	Хавирган цуулдас	1	-	-
9	Сегмент хэлбэрийн цуулдас	-	2	-
10	Хагархай	2	4	-
<b>Нийт</b>		<b>30</b>	<b>62</b>	<b>1</b>




Диаграм-1. Чулуун зэвсгийн зүйлсийн тоон харьцуулалт




Зураг 1. Хойд Тамирын голын хөндий дэх чулуун зэвсгийн зарим дурсгалт газрууд



Зураг 2. 1, 12 - Хусуур; 2,3 - Ялтсан цуулдас; 4, 16-18 - Залтас;  
5 - Хавирган цуулдас; 6 - Үлдэц хэлбэрийн хагархай; 7, 9 - Үлдэц; 8 - Хянгар;  
10, 11 - Цоолтуур; 13-15 - Шүдлэг хүнхэр иртэй зэвсэг



Зураг 3. 1 - Чоптинг; 2-6 - Үлдэц; 7, 9, 11, 12 - Хусуур; 8 - Цоолтуур;  
10 - Хамар хэлбэрийн зэвсэг; 13 - Хосолмол зэвсэг; 14, 15 - Холтослуур



Зураг 4. 1, 2, 3 - Сийлүүр; 4 - Бэлдэц; 6 - Шүдлэг хүнхэр иртэй зэвсэг;  
 7 - Иртэй ялтас; 8 - Хүнхэр иртэй зэвсэг; 9 - Хатгуур;  
 5, 10 - Цоолтуур; 11 - Техникийн цуулдас; 12 - Хусуур;  
 13, 14 - Сегмент хэлбэрийн цуулдас; 15-19 - Залтас